



**МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр,
Утас: 264216, Факс: 264460,
E-mail: info@csc.gov.mn

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛД

Зураг

2022.03.22 № 02/586
танай _____-ны № _____-т

Тогтоол хүргүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар Дундговь аймаг дахь Салбар зөвлөлийн даргыг чөлөөлж, томилох тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Иймд “Салбар зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгчийг чөлөөлж, томилох тухай” 67 дугаар тогтоолыг үүгээр хүргүүлж байна.

Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

ГИШҮҮН



Д.БААТАРСАЙХАН



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

Салбар зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгчийг
чөлөөлж, томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Монгол Улсын Их хурлын 2019 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 17 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 5.6 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Ц.Мөнгөнцоожийг Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь Салбар зөвлөлийн гишүүн, даргын үүрэг гүйцэтгэгчээс чөлөөлж, Ш.Төрбатыг 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс тус Салбар зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгчээр томилсугай.

2.Төрийн албаны тухай хууль тогтоомж, “Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж, орон нутгийн хүний нөөцийн удирдлагыг хууль, эрх зүйн хүрээнд удирдан зохион байгуулж ажиллахыг Салбар зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгч (Ш.Төрбат)-д үүрэг болгосугай.

3.Тус салбар зөвлөлийн даргыг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж буй байдалд нь хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Ж.Эрдэнэбат)-д даалгасугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ

22050163